



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.07.26 № 1/4024

танай 2022.05.31 -ны № 01/921 -Т

**Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн
хийсэн тухай**

Харилцаа холбооны зохицуулах хорооны “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журамд нэмэлт оруулах тухай” 2022 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4825 дугаарт бүртгэлтэй Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 3, 7, 8, 9 дүгээр зүйлүүдэд оруулсан өөрчлөлт, 3, 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйлүүдэд оруулсан нэмэлт, мөн журмын 4.1, 6.3 дахь заалтыг хассаныг тус тус хүлээн авч, холбогдох хөдөлгөөн хийснийг үүгээр мэдэгдье.



Х.НЯМБААТАР



Faint, illegible text in the upper right quadrant of the page, possibly bleed-through from the reverse side.

Faint, illegible text in the middle of the page, possibly bleed-through from the reverse side.

...ДАА ХОЛБООНЫ	
...ЦУУЛАХ ХОРОО	
ТТН.ж.2069	
Бүртгэсэн № ... карт №1929	
Өгнөө 2022.07.28	
09 ... цаг . 30 ... минутанд	
... д	
шилжүүлэв.	



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 07 сарын 26 ны
өдөр хүлээн авсан.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

“Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус хорооны 2020 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д энэхүү тогтоолын хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.


ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн



17 тоот тогтоолын
хавсралт

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 35 дугаар тогтоолын
хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д
оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд

Нэг. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 3, 7, 8, 9 дүгээр зүйлүүдэд дор дурдсан агуулгатай 3.1, 3.2, 3.3, 7.1.1, 7.1.6, 7.2.3, 7.2.4, 8.1, 8.2.3, 8.4.1, 8.4.2, 8.4.3, 8.5, 9.2, 9.3, 9.3.1, 9.3.2, 9.3.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11, 9.12 заалтыг дараах байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

“3.1 MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэр болон түүний дэд домэйн нэр /цаашид “Дэд домэйн нэр” гэх/-ийн иж бүрдэл нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.

3.2 MN домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 3-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.

3.3 Дэд домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 2-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.”

7.1.1. хоёр болон түүнээс дээш интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд тав буюу түүнээс дээш домэйн нэрийн DNS серверийг байрлуулах;

7.1.6. төрийн мэдээлэл солилцоо, нэвтрэлтийн танилтын системүүдээр домэйн нэрийг баталгаажуулах боломж бүрдүүлэх;

7.2.3. холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;

7.2.4. Энэ журмын 2.3-т заасан мэдээлэл болон 6.1.8-д заасан домэйн нэрийн нөөцийг олон нийтэд мэдээлнэ.

7.4. Бүртгэгч нь Зохицуулах хорооны батлагдсан маягтын дагуу хагас жилийн статистик тайлан мэдээллээ тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор, жилийн статистик тайлан мэдээллээ дараа оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Зохицуулах хороонд хүргүүлнэ.

8.1. Бүртгэгч нь домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээ эрхлэх тодорхой эрхийг гэрээний үндсэн дээр Харилцаа холбооны зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээтэй хуулийн этгээдэд олгож болно. Бүртгэлийн үйлчилгээ эрхлэх ийм этгээдийг Гэрээт бүртгэгч гэж нэрлэнэ.

8.2.3.энэ журмын 2.3-д заасан мэдээлэл болон 6.1.8-д заасан домэйн нэрийн нөөцийг олон нийтэд мэдээлэх;

8.4.1.интернэтийн дундын холболтын төвд интернэтийн үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан холбогдсон байх;

8.4.2.төрийн мэдээлэл солилцоо, нэвтрэлтийн танилтын системүүдэд бүртгэгчээр дамжуулан холбогдох;

8.4.3.энэ журмын 7.2.1-т заасан сервер, системд хандахдаа кибер болон биет аюулгүй байдлыг хангах.

8.5 Гэрээт бүртгэгч нь Зохицуулах хорооны батлагдсан маягтын дагуу хагас жилийн статистик тайлан мэдээллээ тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор, жилийн статистик тайлан мэдээллээ дараа оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Зохицуулах хороонд хүргүүлнэ.

9.2. Өргөдөл хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон энэ журмыг баримтална. Монгол Улсын хууль тогтоомж болон энэ журамд заагаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Олон улсын интернэтийн цахим нэр, тоон хаягжилтын корпорацын Домэйн нэрийн тухай маргааныг шийдвэрлэх бодлого /UDRP/-ын холбогдох хэсгийг баримталж болно.

9.3. Иргэн, хуулийн этгээд нь өргөдөл, гомдол гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

9.3.1. Өргөдөл, гомдол гаргах болсон шалтгаан, нөхцөлийг агуулсан албан бичиг, өргөдөл;

9.3.2. Иргэний хувьд иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

9.3.3. Энэхүү журмын хавсралтад заасан маягтыг бөглөх;

9.4. Зохицуулах хороо нь өргөдөл, гомдлыг хүлээн авч иж бүрдлийг шалгах бөгөөд энэхүү журмын 9.3-т заасан баримт бичиг дутуу тохиолдолд өргөдөл, гомдолд дурдсан хаягаар буцаана.

9.5. Энэхүү журмын 9.4-т заасан нөхцөл байдал тогтоогдоогүй тохиолдолд Зохицуулах хорооны ажлын алба өргөдөл, гомдлыг хүлээн авч өргөдөл, гомдолд хамаарах талуудад мэдэгдэж, холбогдох тайлбар, мэдээлэл, баримт бичгийг гаргуулан авна.

9.6. Энэхүү журмын 9.5-д заасны дагуу өргөдөл, гомдолд хамаарах талууд нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор холбогдох тайлбар, мэдээлэл, баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

9.7. Өргөдөл, гомдолд хамаарах талууд нь энэхүү журмын 9.6-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн тохиолдолд Зохицуулах хороо 1 удаа 7 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд заасан хугацаанд хариу ирүүлээгүй нь өргөдөл, гомдлыг хянан үзэхгүй байх үндэслэл болохгүй.

9.8. Өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл домэйн нэрийн эзэмшлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахыг хориглоно.

9.9. Зохицуулах хорооны дарга шаардлагатай тохиолдолд маргаан бүхий асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий 3 гишүүний бүрэлдэхүүнтэй комиссыг томилон ажиллуулж болно. Ингэхдээ талуудын оролцоог хангах бөгөөд өргөдөл, гомдол гаргагч болон холбогдогч тал энэхүү журмын 6.1.8-д заасан жагсаалтаас тус бүр нэг гишүүн санал болгоно. Комиссын ахлагчийг мөн энэхүү жагсаалтаас сонгож Зохицуулах хорооны дарга томилно.

9.10. Энэхүү журмын 9.9-д заасан талууд эсхүл талуудын аль нэг нь комиссын гишүүн санал болгоогүй тохиолдолд Зохицуулах хорооны дарга энэхүү журмын 6.1.8-д заасан жагсаалтаас тохиолдлын журмаар сонгож комиссын гишүүдийг бүрдүүлнэ.

9.11. Комисс нь өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор маргаан бүхий асуудлаар хөндлөнгийн дүгнэлт гаргаж, хорооны хуралдаанд танилцуулна. Зохицуулах хороо нь дүгнэлтийг хүлээн авч энэхүү журмын 9.17-д заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

9.12. Комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дүгнэлтээ олонхын саналаар гаргана.” гэж өөрчлөн найруулсугай.

Хоёр. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 3, 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйлүүдэд дор дурдсан агуулгатай 3.4, 5.1.3, 5.5, 5.5.1, 5.5.2, 6.1.9, 7.1.7, 8.2.1, 8.2.2, 8.2.3, 8.4, 8.4.1, 8.4.2, 8.4.3, 9.3.4, 9.3.5, 9.13, 9.14, 9.15, 9.16, 9.17, 9.17.1, 9.17.2, 9.17.3, 9.18, 9.19 дэх заалтыг тус тус нэмсүгэй:

“3.4 хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралт 1-т зааснаас бусад дэд домэйн нэрийг үүсгэх тохиолдолд зөвхөн өөрийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж болно.

5.1.3.бүртгэгчийг солих.

5.5. Домэйн нэр эзэмших хандалтыг дор дурдсаны дагуу сэргээнэ:

5.5.1. энэ журмын 5.2-ыг заасан зөрчлийг арилгасан тохиолдолд Зохицуулах хорооны мэдэгдлийн дагуу хандалтыг сэргээнэ;

5.5.2.зөрчилтэй домэйн нэрийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш 6 сар өнгөрсөн тохиолдолд”

7.1.7.энэ журмын 7.1.2-т заасан сервер, системийн кибер болон биет аюулгүй байдлыг хангах.

6.1.9.домэйн нэрийн гэрээт бүртгэгчид бүртгэлийн гэрчилгээ олгох, цуцлах, түдгэлзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;"

8.2.1. Зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээ авах;

8.2.2. Гэрээт бүртгэгч нь домэйн нэрийн бүртгэгчтэй гэрээ байгуулсан байх;

8.2.3. Энэ журмын 2.3-д заасан мэдээлэл болон 6.1.8-д заасан домэйн нэрийн нөөцийг олон нийтэд мэдээлэх;

8.4 Гэрээт бүртгэгч нь дараах техникийн шаардлагыг хангасан байна:

8.4.1.интернетийн дундын холболтын төвд интернетийн үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан холбогдсон байх;

8.4.2.төрийн мэдээлэл солилцоо, нэвтрэлтийн танилтын системүүдэд бүртгэгчээр дамжуулан холбогдох;

8.4.3.энэ журмын 7.2.1-т заасан сервер, системд хандахдаа кибер болон биет аюулгүй байдлыг хангах."

9.3.4. Өргөдөл, гомдол гаргагчийн эрх, хууль ёс ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдөж байгаа талаарх баримт, материал;

9.3.5. Маргаан бүхий домэйн нэрийг холбогдох хууль журам, гэрээний дагуу эзэмшдэг болон эзэмшиж байсан бол энэ талаарх баримт, материал.

9.13.Комиссын гишүүн нь дараах тохиолдолд татгалзан гарах үүрэгтэй:

9.13.1.өргөдөл гаргагч болон домэйн нэрийг эзэмшигч, эсхүл уг домэйн нэрийг бүртгэсэн бүртгэгч, гэрээт бүртгэгч, эсхүл тэдгээрийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй гэр бүл, төрөл садангийн болон бусад хувийн харилцаатай;

9.13.2.тухайн домэйн нэрийг бүртгэх ажиллагаанд оролцож байсан;

9.13.3.комиссын бүрэлдэхүүнд ажилласнаар ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй;

9.13.4.дүгнэлтийг хараат бусаар гаргаж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

9.14.Энэ журмын 9.13-т заасан нөхцөл байдал тогтоогдсон, эсхүл комиссын гишүүн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд чөлөөлж, энэ журмын 9.8-д заасан журмын дагуу

өөр гишүүнийг томилно. Шинэ гишүүн томилогдсон бол дүгнэлт гаргах хугацааг 14 хоногоор нэг удаа сунгаж болно.

9.15.Энэ журмын 9.9-д заасны дагуу комисс томилох шаардлагагүй тохиолдолд Зохицуулах хорооны тухайн асуудал хариуцсан нэгж хариу тайлбарыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор асуудлыг судалж, дүгнэлт бэлтгэнэ.

9.16.Өргөдлийг Зохицуулах хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагч болон домэйн нэр эзэмшигчийг Зохицуулах хорооны хуралдаанд оролцуулж болно.

9.17. Зохицуулах хороо өргөдлийг хянан үзээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

9.17.1.домэйн нэрийн бүртгэлийг цуцлах, шилжүүлэх;

9.17.2.өргөдлийг буцаах;

9.17.3.нэмэлт ажиллагаа хийлгэхээр Ажлын албанд буцаах.

9.18.Зохицуулах хорооны шийдвэрийг өргөдөл гаргагч, домэйн нэрийн эзэмшигчид 7 хоногийн дотор албажуулж, цахим болон баталгаат шуудангаар хүргүүлнэ.

9.19.Өргөдөл гаргагч, домэйн нэр эзэмшигч нь Зохицуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.”

Гурав. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.3 дах заалтыг тус тус хассугай.

Дөрөв. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 4.2, 4.3, 4.3.1, 4.3.2, 4.3.3, 4.3.4, 4.3.5, 4.3.6, 4.3.7, 4.3.8, 4.3.9, 4.3.10, 4.3.11, 4.3.12, 4.4, 4.4.1, 4.4.2, 4.4.3, 4.4.4, 4.4.5, 4.4.6, 4.5, 4.6 гэсэн дугаарын “4.1, 4.2, 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9, 4.2.10, 4.2.11, 4.2.12, 4.3, 4.3.1, 4.3.2, 4.3.3, 4.3.4, 4.3.5, 4.3.6, 4.4, 4.5” гэж, 5 дугаар зүйлийн “5.5, 5.5.1, 5.5.2, 5.5.3, 5.5.4, 5.5.5, 5.5.6” гэсэн дугаарыг “5.6, 5.6.1, 5.6.2, 5.6.3, 5.6.4, 5.6.5, 5.6.6” гэж, 6 дугаар зүйлийн “6.1.9, 6.1.10, 6.1.10” гэсэн дугаарыг “6.1.10, 6.1.11, 6.1.12”, 8 дугаар зүйлийн “8.4” гэсэн дугаарын “8.5” гэж тус тус өөрчилсүгэй.

----- оОо -----

“ДОМЭЙН НЭРИЙГ БҮРТГЭХ, АШИГЛАХ ЖУРАМ”-ЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, 3 дугаар зүйлийн 3.1.16 болон 12 дугаар зүйлийн 12.3 -д заасныг тус тус үндэслэн “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг боловсруулсан.

Төслийг боловсруулахдаа Олон Улсын Интернэтийн Цахим нэр, Тоон хаягжилтийн байгууллага (ICANN) -ын бодлого, зохицуулалттай уялдуулж эрхзүйн хувьд ижил төсөөтэй улс орнуудын туршлагыг судлан үзэж, журмын заалтуудад тусгасан болно.

Монгол үндэсний МОН болон .MN өргөтгөл бүхий домэйн нэрийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, үндэсний домэйн нэрийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, домэйн нэр олгох үйл ажиллагааны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг сайжруулах, олон нийтэд чанартай аюулгүй интернэтийн орчин бий болгох, домэйн нэр эзэмшигчийн болон эцсийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг зохицуулалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор журмын нэмэлт өөрчлөлтийг боловсруулсан.

Домэйн нэрийг ашиглах, бүртгэх журмын нэмэлт, өөрчлөлтийг төслийг Зохицуулах хорооны веб сайтад 2020 оны 04 дүгээр сарын 04-нөөс 05 дугаар сарын 04-ний хооронд олон нийтээс санал авахаар байршуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Интернэтийн үйлчилгээ эрхлэгч, Домэйн нэрийн үндсэн бүртгэгч болох Датаком ХХК, Домэйн нэрийн гэрээт бүртгэгчид, Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид зэрэг нийт 29 байгууллагад албан бичиг хүргүүлж, 5 байгууллагаас санал хүлээн авсан.

“Домэйн нэрийг ашиглах, бүртгэх журам”-ын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Датаком ХХК, Мобинет ХХК, Юнивишн ХХК, Юнител групп ХХК, Мобиком групп ХХК зэрэг 5 байгууллагаас нийт 17 санал ирүүлсэн. Журмын төслийн боловсруулах, саналыг тусгах зорилгоор хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 10 саналыг төсөлд тусгаж, эцэслэн боловсруулсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хорооны 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын 17 дугаар “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг баталсан болно.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2022 оны 06 дугаар сарын 17


**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ
ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**
/”Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлт”/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1	акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 болон 9 дүгээр зүйлийн 9.1.14-д заасны дагуу “Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам”-ыг Харилцаа холбооны зохицуулах хороо батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрх олгогдсон. Мөн Харилцаа холбооны тухай хуулийн 12.3. тусгай зөвшөөрөлтэй явуулах үйл ажиллагаанаас бусад харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд Зохицуулах хороонд бүртгүүлнэ гж заасны дагуу домэйн нэр бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тус хороонд бүртгүүлэх үүрэг үүссэн.
2		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох	Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 -д заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны эрхийн хүрээнд “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ыг батлсанаар Монгол Улсын MN болон МОН өргөтгөл бүхий домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах боломж бүрдэнэ.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.
4	тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	Харилцаа холбооны тухай хуульд заасны дагуу домэйн нэрийг бүртгэх үйл ажиллагааг явуулахтай холбоотойгоор бүртгэгч байгууллага, түүний үйл ажиллагааны талаар мөн домэйн нэрийг бүртгэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавихад чиглэгдэнэ.
5		Бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг заах	Энэхүү тогтоол нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасныг үндэслэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6		Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Бүтцийн хувьд: 10 зүйл, 51 хэсэг болон 106 дэд хэсэгтэй.

7	<p>акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох</p>		<p>Журмын нэмэлт, өөрчлөлт батлагдснаар домэйн нэрийн бүртгэгч байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй болно.</p> <p>Одоо үйл ажиллагаа эрхэлж буй домэйн нэрийн бүртгэгч байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсаар 2022 оны 04 дүгээр сарын 04-нөөс 05 дугаар сарын 04-ны өдрийг хооронд санал авахаар байршуулсан.</p> <p>Хууль зүйн, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Датаком ХХК, Үндэсний дата төв УТҮГ, Интернетийн үйлчилгээ эрхлэгчид, Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид зэрэг нийт 29 байгууллагад албан бичиг хүргүүлж, 5 байгууллагаас санал ирүүлснийг журмын нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгасан.</p> <p>Журмын төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны Даргын зөвлөлийн хурлаар 2 удаа танилцуулж, Хорооны хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлж, батлуулсан.</p>
8	<p>хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх</p>	<p>Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх</p>	<p>Үгүй</p>
9		<p>Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх</p>	<p>Үгүй</p>
10		<p>Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх</p>	<p>Тийм</p>
11		<p>Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж хуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх</p>	<p>Үгүй</p>
12		<p>Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх</p>	<p>Үгүй</p>
13		<p>Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх</p>	<p>Үгүй</p>
14		<p>Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх</p>	<p>Үгүй</p>
15		<p>Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх</p>	<p>Үгүй</p>
16	<p>Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;</p>	<p>Үгүй</p>	

17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үүсээгүй
20		Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21		Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй
22	актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог хийх	Захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

ТАНИЛЦСАН

..... 


Б.МЯГМАРНАРАН /Зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх газрын дарга/

ТАНИЛЦСАН

..... 


З.ЭРДЭНЭЧУЛУУН /ЗУХАГ-ын дарга/

ТАНИЛЦСАН


..... 

Т.УУГАНБАТ /ЗУХАГ-ын Хуулийн хэлтсийн дарга/

БОЛОВСРУУЛСАН

..... 

Т.БАТБОЛД /Интернэтийн сүлжээ үйлчилгээний хэлтсийн дарга/

..... 

Г.БАТТУЛГА /Интернэтийн сүлжээ үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн/

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр.

САНАЛЫН НЭГТГЭЛ				
№	ЖУРМЫН ТӨСЛИЙН ЗААЛТ	САНАЛЫН АГУУЛГА	ИРҮҮЛСЭН САНАЛ	ТАЙЛБАР
Нэгдүгээр зүйл – Нийтлэг үндэслэл;				
Нэгдүгээр зүйлтэй холбоотой санал ирүүлээгүй.				
Гуравдугаар зүйл – Домэйн нэрийн бүрдэл, түүнд тавих шаардлага				
3.	<p>3.1. MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэр болон түүний дэд домэйн нэр /Цаашид “Дэд домэйн нэр” гэх/-ийн иж бүрдэл нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>3.2 MN домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 3-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.</p> <p>3.3 Дэд домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 2-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.</p> <p>3.4 хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралт 1-т зааснаас бусад дэд домэйн нэрийг үүсгэх тохиолдолд зөвхөн өөрийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж болно.</p>			Санал ирүүлээгүй.

Дөрөвдүгээр зүйл – Домэйн нэрийг олгох, бүртгэх үйл ажиллагаа				
4.1	Харилцаа холбооны зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээ авсан хуулийн этгээд /цаашид “Бүртгэгч” гэх/ нь домэйн нэрийг бүртгэх үйл ажиллагааг эрхэлж болно	Хасах санал		“8.2. Гэрээт бүртгэгч нь дараах үүрэг хүлээнэ: 8.2.1. Зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээ авах;” гэж найруулсан.
Тавдугаар зүйл – Домэйн нэр эзэмшигчийн эрх, үүрэг				
5.1.3.	бүртгэгчийг солих	Санал ирүүлээгүй.		
5.5.	Домэйн нэр эзэмших хандалтыг дор дурдсаны дагуу сэргээнэ: 5.5.1. энэ журмын 5.2-ыг заасан зөрчлийг арилгасан тохиолдолд зохицуулах хорооны мэдэгдлийн дагуу хандалтыг сэргээнэ; 5.5.2.зөрчилтэй домэйн нэрийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш 6 сар өнгөрсөн тохиолдолд	Санал ирүүлээгүй.		
зургаадугаар зүйл – Домэйн нэрийг олгох, бүртгэх үйл ажиллагаа				
6.1.2.	Зохицуулах хороо нь MN домэйн нэрийн зохицуулалтын хүрээнд Олон улсын интернэтийн цахим нэр, тоон хаягжилтын байгууллага /ICANN/-тай хамтран ажиллах;	Өөрчлөн найруулах	“домэйн нэр бүртгэх үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах;”	Саналыг тусгасан.
6.1.3.	Монгол Улсын MN болон МОН өргөтгөлтэй Домэйн нэрийн сангийн үндсэн бүртгэлд хандах, ашиглалтад хяналт тавих;	Хасах санал		“домэйн нэрийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих” гэж найруулсан.
6.1.10.	домэйн нэрийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг батлан мөрдүүлэх;	Хасах санал		Саналын дагуу хассан.

6.1.11.	домэйн нэрийн үнэ тарифд хяналт тавих;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Долоодугаар зүйл – омэйн нэрийн бүртгэгч, түүний чиг үүрэг				
7.1.1.	домэйн нэрийн DNS сервер 5 буюу түүнээс дээш сервертэй байх;	Өөрчлөх санал	Хоёр ондоо сүлжээнд гэдэг санааг тусгах	”хоёр болон түүнээс дээш интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд тав буюу түүнээс дээш домэйн нэрийн DNS серверийг байрлуулах;”
7.3.1.	Зохицуулах хороонд бүртгүүлэх;	Хасах санал		“домэйн нэрийн гэрээт бүртгэгчид бүртгэлийн гэрчилгээ олгох, цуцлах, түдгэлзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих” гэж тусгасан.
7.3.6.	энэ журмын 6.1.10-т заасан хөлс төлөх;	Хасах санал		Саналын дагуу хассан.
7.3.7.	энэ журмын 6.1.11-т заасны дагуу домэйн нэрийн үнэ тарифыг хянуулах;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Наймдугаар зүйл – Гэрээт бүртгэгч, түүний чиг үүрэг				
8.2.5.	энэ журмын 6.1.10-т заасан хөлс төлөх;	Хасах санал		Саналын дагуу хассан.
8.2.6.	энэ журмын 6.1.11-т заасны дагуу домэйн нэрийн үнэ тарифыг хянуулах;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Нэмэлт саналууд				
1	Хавсралт 1: pr/per – “Монгол Улсын иргэн” гэсэн өргөтгөлийг хасах			Саналын дагуу хассан.

“ДОМЭЙН НЭРИЙГ БҮРТГЭХ, АШИГЛАХ ЖУРАМ”-ЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, 3 дугаар зүйлийн 3.1.16 болон 12 дугаар зүйлийн 12.3 -д заасныг тус тус үндэслэн “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг боловсруулсан.

Төслийг боловсруулахдаа Олон Улсын Интернэтийн Цахим нэр, Тоон хаягжилтийн байгууллага (ICANN) -ын бодлого, зохицуулалттай уялдуулж эрхзүйн хувьд ижил төсөөтэй улс орнуудын туршлагыг судлан үзэж, журмын заалтуудад тусгасан болно.

Монгол үндэсний МОН болон .MN өргөтгөл бүхий домэйн нэрийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, үндэсний домэйн нэрийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, домэйн нэр олгох үйл ажиллагааны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг сайжруулах, олон нийтэд чанартай аюулгүй интернэтийн орчин бий болгох, домэйн нэр эзэмшигчийн болон эцсийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг зохицуулалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор журмын нэмэлт өөрчлөлтийг боловсруулсан.

Домэйн нэрийг ашиглах, бүртгэх журмын нэмэлт, өөрчлөлтийг төслийг Зохицуулах хорооны веб сайтад 2020 оны 04 дүгээр сарын 04-нөөс 05 дугаар сарын 04-ний хооронд олон нийтээс санал авахаар байршуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Интернэтийн үйлчилгээ эрхлэгч, Домэйн нэрийн үндсэн бүртгэгч болох Датаком ХХК, Домэйн нэрийн гэрээт бүртгэгчид, Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид зэрэг нийт 29 байгууллагад албан бичиг хүргүүлж, 5 байгууллагаас санал хүлээн авсан.

“Домэйн нэрийг ашиглах, бүртгэх журам”-ын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Датаком ХХК, Мобинет ХХК, Юнивишн ХХК, Юнител групп ХХК, Мобиком групп ХХК зэрэг 5 байгууллагаас нийт 17 санал ирүүлсэн. Журмын төслийн боловсруулах, саналыг тусгах зорилгоор хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 10 саналыг төсөлд тусгаж, эцэслэн боловсруулсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хорооны 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын 17 дугаар “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг баталсан болно.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2022 оны 06 дугаар сарын 17

**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ
ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

/“Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын нэмэлт, өөрчлөлт/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1	акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 болон 9 дүгээр зүйлийн 9.1.14-д заасны дагуу “Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам”-ыг Харилцаа холбооны зохицуулах хороо батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрх олгогдсон. Мөн Харилцаа холбооны тухай хуулийн 12.3. тусгай зөвшөөрөлтэй явуулах үйл ажиллагаанаас бусад харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд Зохицуулах хороонд бүртгүүлнэ гж заасны дагуу домэйн нэр бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тус хороонд бүртгүүлэх үүрэг үүссэн.
2		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох	Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 -д заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны эрхийн хүрээнд “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ыг батлсанаар Монгол Улсын МН болон МОН өргөтгөл бүхий домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах боломж бүрдэнэ.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.
4	тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	Харилцаа холбооны тухай хуульд заасны дагуу домэйн нэрийг бүртгэх үйл ажиллагааг явуулахтай холбоотойгоор бүртгэгч байгууллага, түүний үйл ажиллагааны талаар мөн домэйн нэрийг бүртгэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавихад чиглэгдэнэ.
5		Бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг заах	Энэхүү тогтоол нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасныг үндэслэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6		Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Бүтцийн хувьд: 10 зүйл, 51 хэсэг болон 106 дэд хэсэгтэй.

7	акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох		<p>Журмын нэмэлт, өөрчлөлт батлагдснаар домэйн нэрийн бүртгэгч байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй болно.</p> <p>Одоо үйл ажиллагаа эрхэлж буй домэйн нэрийн бүртгэгч байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсаар 2022 оны 04 дүгээр сарын 04-нөөс 05 дугаар сарын 04-ны өдрийг хооронд санал авахаар байршуулсан.</p> <p>Хууль зүйн, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Датаком ХХК, Үндэсний дата төв УТҮГ, Интернетийн үйлчилгээ эрхлэгчид, Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид зэрэг нийт 29 байгууллагад албан бичиг хүргүүлж, 5 байгууллагаас санал ирүүлснийг журмын нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгасан.</p> <p>Журмын төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны Даргын зөвлөлийн хурлаар 2 удаа танилцуулж, Хорооны хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлж, батлуулсан.</p>
8	хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй
9		Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй
10		Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
11		Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж хуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй
12		Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй
13		Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх	Үгүй
14		Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх	Үгүй
15		Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	Үгүй
16	Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй	

17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үүсээгүй
20		Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21		Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй
22	актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог хийх	Захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

ТАНИЛЦСАН

..... 

Б.МЯГМАРНАРАН /Зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх газрын дарга/

ТАНИЛЦСАН

..... 



З.ЭРДЭНЭЧУЛУУН /ЗУХАГ-ын дарга/

ТАНИЛЦСАН

..... 

Т.УУГАНБАТ /ЗУХАГ-ын Хуулийн хэлтсийн дарга/

БОЛОВСРУУЛСАН

..... 
..... 

Т.БАТБОЛД /Интернэтийн сүлжээ үйлчилгээний хэлтсийн дарга/

Г.БАТТУЛГА /Интернэтийн сүлжээ үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн/

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр.

САНАЛЫН НЭГТГЭЛ				
№	ЖУРМЫН ТӨСЛИЙН ЗААЛТ	САНАЛЫН АГУУЛГА	ИРҮҮЛСЭН САНАЛ	ТАЙЛБАР
Нэгдүгээр зүйл – Нийтлэг үндэслэл;				
Нэгдүгээр зүйлтэй холбоотой санал ирүүлээгүй.				
Гуравдугаар зүйл – Домэйн нэрийн бүрдэл, түүнд тавих шаардлага				
3.	<p>3.1. MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэр болон түүний дэд домэйн нэр /Цаашид “Дэд домэйн нэр” гэх/-ийн иж бүрдэл нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>3.2 MN домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 3-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.</p> <p>3.3 Дэд домэйн нэр нь англи цагаан толгойн үсгийн A-Z ба a-z болон 0-9 хүртэлх цифр; МОН өргөтгөлтэй домэйн нэр нь монгол цагаан толгойн үсгийн А-Я ба а-я болон 0-9 хүртэлх цифр, “-” хашилтын тэмдэг зэрэг 2-аас доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна.</p> <p>3.4 хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралт 1-т зааснаас бусад дэд домэйн нэрийг үүсгэх тохиолдолд зөвхөн өөрийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж болно.</p>			Санал ирүүлээгүй.

Дөрөвдүгээр зүйл – Домэйн нэрийг олгох, бүртгэх үйл ажиллагаа				
4.1	Харилцаа холбооны зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээ авсан хуулийн этгээд /цаашид “Бүртгэгч” гэх/ нь домэйн нэрийг бүртгэх үйл ажиллагааг эрхэлж болно	Хасах санал		“8.2. Гэрээт бүртгэгч нь дараах үүрэг хүлээнэ: 8.2.1. Зохицуулах хорооноос бүртгэлийн гэрчилгээ авах;” гэж найруулсан.
Тавдугаар зүйл – Домэйн нэр эзэмшигчийн эрх, үүрэг				
5.1.3.	бүртгэгчийг солих	Санал ирүүлээгүй.		
5.5.	Домэйн нэр эзэмших хандалтыг дор дурдсаны дагуу сэргээнэ: 5.5.1. энэ журмын 5.2-ыг заасан зөрчлийг арилгасан тохиолдолд зохицуулах хорооны мэдэгдлийн дагуу хандалтыг сэргээнэ; 5.5.2.зөрчилтэй домэйн нэрийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш 6 сар өнгөрсөн тохиолдолд	Санал ирүүлээгүй.		
зургаадугаар зүйл – Домэйн нэрийг олгох, бүртгэх үйл ажиллагаа				
6.1.2.	Зохицуулах хороо нь MN домэйн нэрийн зохицуулалтын хүрээнд Олон улсын интернэтийн цахим нэр, тоон хаягжилтын байгууллага /ICANN/-тай хамтран ажиллах;	Өөрчлөн найруулах	“домэйн нэр бүртгэх үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах;”	Саналыг тусгасан.
6.1.3.	Монгол Улсын MN болон МОН өргөтгөлтэй Домэйн нэрийн сангийн үндсэн бүртгэлд хандах, ашиглалтад хяналт тавих;	Хасах санал		“домэйн нэрийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих” гэж найруулсан.
6.1.10.	домэйн нэрийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг батлан мөрдүүлэх;	Хасах санал		Саналын дагуу хассан.

6.1.11.	домэйн нэрийн үнэ тарифд хяналт тавих;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Долоодугаар зүйл – омэйн нэрийн бүртгэгч, түүний чиг үүрэг				
7.1.1.	домэйн нэрийн DNS сервер 5 буюу түүнээс дээш сервертэй байх;	Өөрчлөх санал	Хоёр ондоо сүлжээнд гэдэг санааг тусгах	"хоёр болон түүнээс дээш интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд тав буюу түүнээс дээш домэйн нэрийн DNS серверийг байрлуулах;"
7.3.1.	Зохицуулах хороонд бүртгүүлэх;	Хасах санал		"домэйн нэрийн гэрээт бүртгэгчид бүртгэлийн гэрчилгээ олгох, цуцлах, түдгэлзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих" гэж тусгасан.
7.3.6.	энэ журмын 6.1.10-т заасан хөлс төлөх;	Хасах санал		Саналын дагуу хассан.
7.3.7.	энэ журмын 6.1.11-т заасны дагуу домэйн нэрийн үнэ тарифыг хянуулах;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Наймдугаар зүйл – Гэрээт бүртгэгч, түүний чиг үүрэг				
8.2.5.	энэ журмын 6.1.10-т заасан хөлс төлөх;	Хасах санал		Саналын дагуу хассан.
8.2.6.	энэ журмын 6.1.11-т заасны дагуу домэйн нэрийн үнэ тарифыг хянуулах;	Хасах санал		Саналын дагуу хассан.
Нэмэлт саналууд				
1	Хавсралт 1: pr/per – "Монгол Улсын иргэн" гэсэн өргөтгөлийг хасах			Саналын дагуу хассан.